

Манмин Мэдээ

№ 55 2015 оны 2 сарын 1



2014 оны Христмас
баярыг эргэн дурсахад

2014 оны 12-р сарын 19-ний 21:50 нд Сүлд модны гэрэл асаах ёслолыг GCN (Жи Си Эн) ТВ-р шууд дамжуулан нэвтрүүлсэн бөгөөд Эзэний мэндэлсэн өдрийг тэмдэглэхээр мянга мянган итгэгчид уг үйл ажиллагаанд ирж оролцлоо. Урьд өдрүүд цаг агаар маш хүйтэн жижүүн хасах градустай байсан ч яг тэр өдөр нэмэх градустай болж маш сайхан дулаахан орой болсон юм. И Жей руг пастор бидний Эзэн идэж, уух ч үгүй Бурханы сэнтийн баруун талд зогсоод бидний төлөө тасралтгүй, уйгагүй залбиран гуйж байгаа учраас Түүний энэ агуу хайрыг санан хичээнгүйлэн зүтгэж, маш хурдан өсөх хэрэгтэй байна гэж уг үйл ажиллагаанд оролцогчдод хэлсэн юм.

Хайрын үр жимс, Дахин бүтээх хүч нөлөө нь хүний зүрх сэтгэлийг шинэчилж, Конго бүгд найрамдах улсын залбирлын хүсэлтээр тэнд тархаад буй Ебола вирусыг бүрэн устгалаа

2014 он бол Манмины итгэгчдийн хувьд маш их баярлан хөөрч бас зарим үед тэр хэмжээгээр нулимс урсгасан жил байлаа. Хоньчны золиос, ба үйлчлэлээр дамжуулан ухаарсан Бурханы хайр, Эзэний хайр нь бидний төсөөлж байснаас ч илүү байсан юм. Энэ агуу хайр биднийг үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөр, ба сэтгэл хөдлөлийг, түүнчлэн заримдаа хязгааргүй мэт нулимс унагааж байлаа.

2014 онд Бурхан 'Би хэрэгжүүлнэ' (Иохан 14:13-14), 'Үйлчлэл' (Үйлс 19:12), 'Гэрэлтэх өргөө' (илчлэлт 21:2), 'Дахин бүтээх хүч' (Эхлэл 1:3) гэсэн 4 залбирлын сэдвийг өгсөн. Итгэгчид хоньчинтойгоо нэгдэн чин сэтгэлээсээ гал халуун залбирсан. Түүний үр дүнд 'Би хэрэгжүүлнэ' (Иохан 14:13-14) үгнийн дагуу жилийн эхнээс И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар дамжуулан Дауны хам шинж буюу ургийн гаж хөгжил гэж оношлогдсон маш олон хүүхдүүд цоо эрүүл, эсэн мэнд төрж, эрүүл саруул өсөж бойжиж байна. Дауны хам шинж буюу ургийн гаж хөгжил гэдэг нь анагаах ухааны хувьд эмчлэх ямар ч боломжгүй олдмол буюу удам дамжсан эмгэг бөгөөд ийм ураг эхийн хэвлийд хэвийн бойжсон

ч төрөөд амьдрах чадвар маш муу эсвэл насан туршдаа хөгжлийн бэрхшээлтэй юм уу оюун ухааны хомсдолтой хүн болох юм. Гэтэл И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар дамжуулан Бурханы 'Би хэрэгжүүлнэ' (Иохан 14:13-14) үгийн дагуу энэ хам шинж өвчин төгс эдгэрч, тэр ч байтугай хэдийн хүйс нь тодорхойлогдсон ч эцэг эхийнх нь итгэлийнх нь дагуу хүссэнээр өөрчлөгдөж байсан юм. Энэ бүхнийг хараад итгэгчид Бурхан 'Би хэрэгжүүлнэ' (Иохан 14:13-14) гэж айлдсан нь ямар угтагай байсныг ойлгосон юм.

Ялангуяа 2014 оны зуны цуглааны эхний өдрийн орой эдгэрлийн цуглаан дээр Ариун Сүнсний ажил их дэлбэрэлт мэт болж, олон хүн өвчнөөсөө ангижран эдгэрч байлаа. Хамгийн гайхамшигтай нь И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлаар Конго бүгд найрамдах улсад тархаад байгаа Ебола вирусын тархалт зогссон юм. Энэ тухай Конго улсад оршин сууж буй Себастьян Импетито залбирч өгөхийг гуйжээ. Залбирлын дараа тэр нутагт Ебола вирусын тархалт зогсож 11-р сарын 15нд энэ вирус байхгүй болсон гэж албан ёсоор зарласан байна.

Түүнчлэн 2014 онд 'Үйлчлэл' үй олон хүмүүсийн авралын төлөө идэвхитэй ажилласан жил байлаа. Дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаагаа явуулж буй 10000 гаруй Манмины салбар сүмүүдэд гар алчуурын (Үйлс 19:11-12) 'Эдгэрэл ивээлийн цуглаан' явагдаж, түүнчлэн Манмины пасторууд гадаад улс орнууд руу уригдан 'Эдгэрэл ивээлийн цуглаан' зохион байгуулснаар асар олон хүн эдгэшгүй хүнд өвчнөөсөө эдгэрч, хүнд хэцүү асуудлуудаасаа чөлөөлөгдөн хариултаа авсан билээ. Цаашдаа ч энэ үйлчлэлээ үргэлжлүүлэн эрчимтэй хийж, үйлчлэлийн төлөө Бурханы хүсэлд дуулгавартайгаар ирэх олон сүнслэг дайчид олноор гарч ирсээр байна.

Түүнчлэн юу юунаас ч илүү 'Гэрэлтэх Өргөө'-г босгон байгуулахын тулд манмины итгэгчдийг тэнгэрийн орны хамгийн үзэсгэлэнтэй Шинэ Иерусалимын арван хоёр суурь чулууг бэлэгдэх сүнслэг зүрх сэтгэлтэй болох хүсэл тэмүүлэл ерөөлийг өгсөн билээ. Сүнслэг мөн төгс сүнслэг итгэлтэй болсон итгэгчдийн тоо өсөх тусам дэлхийн нөхцөл байдал ч Бурханы айлдсаны дагуу болж, Түүний тогтоосон цагт санхүүжигдэн орж ирээд

Манмины Канаан сүмийг болоод Гэрэлтэх Өргөөг барих болно.

Мөн түүнээс гадна 'Дахин Бүтээх Хүч' үргэлж үйлчилж угийн дуугаар бүхнийг дахин хийж бүтээж байна. Энэ мэт олон янзын тэмдэгт гайхамшгууд болсон нь үхмэл сүнс дахин амилж, итгэгчдийн зүрх сэтгэл, зан араншин нь уг үндсээрээ үнэн дээр суурилах болсон. Энэ нь 2014 онд сүнсний түвшинд хүрэхэд сүмийн гол хөдөлгөгч хүч болж чадсан билээ.

Бурханы ийм агуу нигүүлсэл дунд Манмин 12-р сарын 28 нд жилийн хурлаа хийж хуучин оны бүх ажил үйлсээ дүгнэн хэлэлцсэн юм. Итгэгчид 2014 онд авсан бүх ивээл ерөөлдөө баярлан, олон зүйлийг ойлгож ухаарч хоньныхоо эцэс төгсгөлгүй золиосонд нь талархаж байна. Тэрээр өөрийн бүх амь, амьдралаа өгч жинхэнэ хайрыг харуулж чадсан юм. Энэ агуу хайрыг хэзээ ч мартаггүй, үргэлж талархах хэрэгтэй гэж итгэгчид ярьж байна. 2015 онд итгэгчид төгс сүнсний урсгал руу илүү их хурдан орж, дэлхий даяарх бүх үндэстэнд сайн мэдээг тунхаглахад өөрсдийгөө бүрэн зориулж, чин сэтгэлээсээ Канаан болон Ариун Өргөөг барихад бэлтгэх болно.

“Чи надаас өөр бурхадтай байж болохгүй”

Бурхан энэ бүх үгсийг айлдсан нь Би бол чамайг боолчлолын гэрээс, Египетийн нутгаас гаргасан чиний Бурхан ЭЗЭН байна.

Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй (Египетээс гарсан нь 20:1-3).



И Жей руг пастор

амьдруулахын төлөө юм. Гэтэл зарим хүн “Хүн яаж бүх арван тушаалыг бүгдийг нь сахиж чадах вэ? Бид сахиулыг хичээж л чадна” гэж хэлж магадгүй юм. Тэгвэл 1 Иохан 5:3 уншвал “Бурханы хайрлах нь Түүний тушаалуудыг сахих юм. Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ” гэсэн байдаг.

Хамгийн хайртай хүн нь тус болооч гэж маш хэцүү зүйлийг хүртэл гуйвал түүнд хайртай бол гуйлтыг нь биелүүлэхдээ ч хүртэл баяр хөөртэй байдаг шиг үнэхээр Бурханд хайртай бол Түүний тушаалуудыг сахин биелүүлэх нь тийм ч хэцүү биш билээ. Хуучин гэрээний үед өөрийн хүч, хичээл зүтгэл, сэтгэлийн тэнхээгээрээ сахин амьдрах шаардлагатай байсан хүмүүсийг бодвол Шинэ Гэрээний үед амьдарч байгаа хүмүүс бидний хувьд маш олон зүйл өөрчлөгдсөн.

Есүс загалмайд цовдлогдож золиослогдсоноор биднийг бүх гэм нүглээс чөлөөлсөн тул Түүнд итгэж, Есүс Христийг хүлээн авсан хүн бүр Ариун Сүнснийг авч, мөн Түүний тусламжийг авдаг.

Хүний хичээл зүтгэл, чармайлтаар сахилах хэцүү зүйл гэсэн Ариун Сүнсний хүчээр хангалттай сахиж чаддаг. Үнэн болох Бурханы үг үнэхээр бидний дотор байгаа л бол гэм нүгэл хийж чадахгүй бөгөөд харин үнэний дагуу амьдрах болно.

2. Бурхан бол Бүтээгч, Аврагч бөгөөд цорын ганц Бурхан юм

Египетээс гарсан нь 20:1-3 уншвал “Бурхан энэ бүх үгсийг айлдсан нь Би бол чамайг боолчлолын гэрээс, Египетийн нутгаас гаргасан чиний Бурхан ЭЗЭН байна. Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй” гэсэн байдаг.

Энд ‘Чи’ гэсэн энэ үг нь Мосед болон үгийг хүлээн авч байгаа Израйль ард түмэнд хандан хэлж байгаа үг юм. Өнөөдөр ч энэ үг нь Бурханы бүх хүүхдүүдэд хандан айлдсан үг юм. Тэр зөвхөн Израйлийн үр удмыг агуу тэмдэгт гайхамшигуудыг үйлдэж Египетын боолчлолоос чөлөөлсөн юм биш гэм нүглийн боол болсон биднийг хүртэл чөлөөлж аварсан билээ. Тиймээс Бурханы хүүхэд бидний хувьд Түүнээс өөр ямар ч бурхадтай байж болохгүй.

Зөвхөн Бурхан л бол цорын ганц үнэн, амьд оршигч, бүхнийг чадагч бөгөөд Тэнгэрийн орон хийгээд тэнгэр, газрыг бүтээж түүнд оршигч бүх зүйлийг бүтээгч Эзэн юм. Тэрээр хүн төрөлхтөний түүх, хүмүүний амьдрал, үхэл, гай гамшиг, аз жаргал гээд бүгдийг нь энэ дэлхийд болж байгаа бүх зүйлийг удирддаг. Тэр бидэнд жинхэнэ үнэн, мөнхийн амийг ч өгдөг. Гэтэл зарим хүмүүс өөрсдийгөө жинхэнэ

Бурханаас тусгаарлаж хоосон, хуурамч олон хиймэл бурхадтай үйлчилдэг. Зарим нь нарны бурхан, долоон одыг ч хүртэл шүтэж байхад зарим нь элдэв дүрс бүхий хуучин хад чулуу, модыг бүр зарим хүмүүс ан амьтадыг хүртэл шүтдэг. Гэтэд тэдний аль нь тэднийг аварч, ивээл ерөөлийг өгч чадаагүй.

Ром 1:20д “Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурханаг төрх нь бүтээгдсэн зүйлсээр дамжуулан ойлгогдон, илэрхий харагдаж байгаа. Иймээс тэдэнд шалтаг байхгүй” гэсэн байдаг. Бүтээгч Эзэний хүч биднийг хүрээлэн байгаа олон зүйлээс илэрхий харагдаж байгаа бөгөөд тэдгээр нь зөвхөн ганц Эзэнээр бүтээгдсэн гэдгээ ч батлан харуулж байдаг.

Энэ дэлхийн бүх хүмүүсийн бүтэц, дотоод эрхтэний үйл ажиллагаа яг ижилхэн байдаг. Африкчууд, Европ, Ази бүх хүмүүс бүгдээрээ л хоёр нүд, хоёр чих, нэг хамар, нэг амтай тэдгээрийн байрлал нь хүртэл яг адилхан газар байдаг. Хүнээр ч зогсохгүй мал амьтных хүртэл адилхан байдаг нь ганцхан Бүтээгч Эзэн байдаг гэж бидэнд хэлж өгч байна. Үүнээс гадна олон байгалийн үзэгдлүүд хүртэл цорын ганц Бүтээгч Бурханыг баталж байдаг.

Дэлхий эргэлддэг учраас өдөр шөнө ээлжилж, дөрвөн улирал далайн давалгаа, усны татлага, түрлэг, агаар мандлын эргэлт болж байдаг. Олон тэнгэрийн эрхэс байрлаж, хөдөлгөөнд орж байгаа нь дэлхий дээр амьдарч байгаа хүн бусад амьтай бүхэнд хамгийн сайн сайхан амьдрах орчинг бүрдүүлэхийн төлөө юм. Нар, газар дэлхий хүртэл өчүүхэн ч алдаа гаргахгүйгээр хэмжихийн аргагүй хугацаанд хамгийн сайн тохиромжтой зайд шилжин хөдөлдөг байна.

Энэ нь Бурхан орчлон ертөнц түүн доторх бүх зүйлийг зохион бүтээж, түүнийгээ Өөрийн мэргэн ухаанаараа ажиллуулж байдаг болохоор энэ бүхэн Түүний хувьд боломжтой юм. Тэр бол цорын ганц Бүтээгч бүх зүйлийг хийсэн, мөн бүх зүйлийг Өөрийн агуу их хүчээрээ ажиллуулж байдаг. Ийм тодорхой баталгаа байгаа болохоор эцэст нь Шүүлтийн өдөр хэн ч бай “Бурхан байсныг би мэдээгүй” гэж хэлэх шалтаг байхгүй.

Хүн төрөлхтөний түүхэнд сайн мэдээг сонсож чадаагүй хүмүүсүүдийн дунд ч цайлган хүмүүс Бүтээгч Эзэн байгааг хүлээн зөвшөөрч, зөв шударгаар амьдарч байсныг харж болох юм. Жусоны агуу жанжин И Сүн-шин ч ялгаагүй тэрээр үргэлж зөв шударга замаар явахыг эрмэлзэж, зөвхөн Бурханд л үйлчилдэг байв. Тэржинхэнэ Бүтээгч Бурхан Эзэнийг мэддэггүй байсан ч утга учиргүй, хиймэл бурхад мөргөж байсангүй. Тэр сайхан

сэтгэлтэй, мөс чанар сайтай байсан тул тэнгэр өөд хараад энэ бүгдийг бүтээсэн агуу Бүтээгч Эзэн бий хэмээн эмээн хүндэлдэг байсан юм.

Зөв шударга Бурхан ийм хүмүүст зориулан аврал хүртэх замыг нээж өгсөн ба Ром 2:14-16-г уншвал ‘мөс чанарын шүүлт’ хэмээн тодорхой гардаг. Хуучин гэрээний үед амьдарч байсан хүмүүсийн дунд сайн мэдээг сонсоогүй, Бурханы хуулийг мэдэхгүй байсан ч сайн мөс чанартай, сайхан сэтгэлээр Бурхан байгаа гэдэгт итгэж амьдарч байсан хүмүүст аврагдах энэхүү замыг нээж өгсөн юм.

3. Надаас өөр бурхадтай байж болохгүй хэмээн тушаасны учир

Бурханд итгэдэг хүмүүсийн дунд ч өөр бурхад ч үйлчилж, мэрэгч төлөгч дээр очиж үгүй бол өөр төрлийн илбэ шид, хараал хийдэг хүмүүст найддаг тохиолдол бий. Тэдний зарим нь бүр элдэв тарни шившлэж, сахиус ч зүүгээд явж байдаг. Зарим нь харь үндэстний шашины ёслолд оролцож, хуурамч бурхад мөргөөд түүнийгээ тухайн нөхцөлд байдалд мэдрэмжтэй, ухаалаг байх гэж тайлбарлаж байна. Зарим үл итгэгчид “Христчин хүмүүс зөвхөн ганцхан Бурханд итгэх хэрэгтэй гэдэг. Энэ чинь хэтэрхий нэг талыг баримталсан хатуу, чанга зарчим юм биш үү?” гэлцдэг.

Гэвч Бурхан бол цор ганц, бөгөөд Бүтээгч Эзэн, Түүнээс өөр хэн ч бидэнд амь, ивээл ерөөлийг өгч чадахгүй. Харин хүмүүсийн үйлчлэлд буй хиймэл хуурамч, бурхад нь харанхуйнх нь бөгөөд Бурханы дайсан саган, муу ёрын сүнснүүдээс хамааралтай юм. Сатан хүмүүсийг төөрөгдүүлж, дэмий хоосон зүйл хийлгэж, итгүүлдэг. Ингэж хоосон зүйлд итгэж үйлчилсэнээр үхлийн замаар, сүйрлийн замаар тэднийг удирдан дагуулж байдаг.

Тиймээс Бурханд итгэдэг гэж хэлдэг ч та нарын дотор өөр бурхад байвал үргэлж бэрхшээл, сорилт амьдралд чинь тулгарч таны амьдрал нулимстай, уй гашуутай, өвчин зовлонтой байх болно. Хайрын Бурхан маань биднийг хиймэл бурхад мөргөж, үйлчилснээс болж сүйрэлд унагахыг хүсэхгүй байгаа учраас л өөр бурхадтай байж болохгүй гэж тушаасан юм. Бурхан биднийг мөнхийн амийг олж аваасай хэмээн Түүнд үйлчилж Түүний үг тушаалын дагуу явж энэ дэлхийд ч ерөөгдсөн амьдралаар амьдраасай гэж хүсдэг.

Хайрт итгэлийн ахан дүүс нар минь, та амьд оршин буй Бурханы баталгааг харж, сонсож, мэдэрсэн тул тэнгэр газрыг бүтээж, бүгдийг удирдан захирдаг Бурханд л хувиршгүйгээр үйлчлэн хүндэтгэхийг хүсье.

Бурханы хүүхдүүд Библийн 66 номын бүх Бурханы үгийг санаж чадахгүй ч гэсэн арван хуулийг бол зайлшгүй сахиж, итгэлийн амьдралын суурь болгон хэрэгжүүлэх ёстой. Арван хууль гэдэг нь Бурхан Өөрийн хайртай хүүхдүүдэдээ зориулан Мосегоор дамжуулан өгсөн арван зүйл тушаал юм. Мөн энэ хууль нь амьд оршигч Бурханы хүүхдүүдэд хандаж айлдсан бүхийл үг ба тушаалын хураангуй хэлбэр нь бөгөөд Библийн чухал хэсэг юм.

1. Итгэгчдийн мэдээж сахих ёстой, бөгөөд хангалттай сахиж чадах Арван хууль

Энэ дэлхийд ч сахих ёстой хууль дүрэм гэж байдаг шиг Есүс Христийг хүлээн авч, Бурханд хамаарагдах итгэгч хүнд ч бас сахих ёстой хууль гэж байдаг.

Энэ хууль нь Библид тэмдэглэгдсэн Бурханы хүмүүст хандсан зарлиг бөгөөд үүнийг 4 хуваан үзэж болох юм. Эдгээр нь “Хий,” “Бүү хий,” “Сахигтун,” “Хаягтун” гэж дөрөв хуваана. Хэрэв бид энэ бүхнийг сахин биелүүлвэл Бурханы хамгаалалтанд байх учир с сатан диавол бидэнд сорилт болон гай зовлонг өгч чадахгүй юм. Харин зөрчвөөс энэ нь гэм нүгэл болох бөгөөд саганы эрх мэдэлд орж гэм нүгэл харанхуйн боолчлолд өөрсдийгөө тавьж өгөөд эцэст нь тэд биднийг там руу удирдан замчлах болно.

Тиймээс бид нар Бурхан чухам яагаад тушаалуудыг өгч сахь, биелүүл, хэрэгжүүл хэмээн айлдсаны учир шалтгааныг нь сайн ойлгох хэрэгтэй. Бурхан биднийг элдэв тушаал зарлигаар хүлж, хүнд хэцүү дарамтанд байлгахыг хүсээгүй харин үүний оронд нулимс, өвчин зовлон, үхэл хагацалгүй, мөнхийн Тэнгэрийн орон руу аваачихыг хүссэн юм. Мөн түүгээр ч зогсохгүй энэ дэлхийд амьдарч байхдаа ч ивээл ерөөлөөр дүүрэн сайхан

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org



Та Ариун Сүнсний Хүчийг мэдэрч байсан уу?

Үйлс номонд Есүс Христийг хүлээн авч Ариун Сүнснийг хүлээн авч, эрх мэдэлт хүчийг авсан элч нар хэрхэн Иерусалим, Иудей, Самари, тэр бүү хэл энэ дэлхийн хязгаар хүртэл сайн мэдээг яаж тарааж байсан тухай гардаг. Ялангуяа, эхний хоёр бүлэгт дээд өрөөнд болсон явдал болон Түүнийг дээшээ хөөрөхөөс өмнө Эзэний дахин амилсаныг батлан нарийвчлан хэлсэн байдаг. Нэг зуун хорин хүн дахин амилсан Эзэний хэлсэний дагуу Ариун Сүнснийг болон хүчийг авахын тулд өөрсдийгөө залбиралд зориулан хамтдаа байсан. Тэгтэл гайхамшигтай зүйл болж тэд бүгдээрээ Ариун Сүнсээр дүүрч өөр хэлээр ярьж, Сүнс тэдэнд үгийг өгч, тэр өдөр гурван зуу орчим хүнээр нэмэгдсэн. Энэ нь анхны Чуулганы эхлэл байсан.

Энэ мэт Ариун Сүнсний ажил нь гэм нүгэлээр дүүрсэн эцсийн өнөө үед үй олон хүний сүнснийг аврахын тулд илүү их хүчтэй гарч, харуулж байна. Одоо Ариун Сүнсний энэхүү хүч чадлыг илүү гүнзгийрүүлэн үзэцгээе.

I. Шархалсан зүрхийг эдгээж, амар тайвныг өгдөг Ариун Сүнсний хүч тагтаа мэт зөөлөн бууж ирдэг

“Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав” (Матай 3:16).

Бурхан Иохан баптистад хэний дээр Сүнс бууж тогтохыг чи харна тэр бол Христ мөн гэж хэлсэн. Тун удалгүй Есүсийг баптисм хүртсэний дараа тэнгэр нээгдэж Сүнс тагтаа мэт бууж ирэхийг хараад Иохан Есүсийг Бурханы Хүү байна гэж таньсан.

Ариун Сүнс тагтаа мэт буух гэдэг нь жинхэнэ тагтаа бууж ирсэн юм биш харин ‘зөөлхөн, аяархан’ доош буух гэдэг үгээр Есүсийн зан чанарыг билэгдэж хэлсэн

үг юм. Энэ нь Ариун Сүнс хүн нэг бүрийн нөхцөл байдал, зан чанарын дагуу өөр өөрөөр арга замаар ажилладаг гэдгийг тайлбарлаж байгаа юм. Ариун Сүнс тагтаа мэт бууж ирэхэд зөвхөн өвчнийг эдгээдэггүй, сүнслэг зүрх сэтгэлийн, оюун санааны, бизнесийн асуудлыг шийдвэрлэдэг. Ингэснээр шархалсан зүрхийг эдгээж, амар тайвныг өгдөг.

II. Салхи мэт сэрүүн Ариун Сүнсний ажил: төгс гэмшил, эдгэрлийн баталгааны ивээл

“Гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний сууцгааж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ” (Үйлс 2:2).

Энэ нь маш хүчтэй салхи мэт хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөн шинэчилдэг. Ариун Сүнс ингэж салхи мэт хүчтэй ажиллах үед түүний хүч агуу гайхамшигтай, асар их хүчээр ажилладаг бөгөөд зарим үед дэлхий даяар нэгэн зэрэг нөлөөлж чаддаг.

Ариун Сүнс ингэж ажиллах үед бид гэмшиж, өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа мэт сайхан мэдрэмж төрдөг. Яг л гаа идсэн юм шиг биеэр сэрүү оргих мэдрэмж төрөх эсвэл шууд өвчинөөсөө эдгэрч илүү сайн болж байгаа нь мэдрэгддэг.

Библид Бурханы мөн чанар, хүчийг хэд хэдэн газар ‘салхи’-аар зүйрлэн тайлбарласан байдаг (Египетээс гарсан нь 14:21; Хаадын Дээд 18:45; Хосеа 13:15). Есүс

Ариун Сүнсний ажлыг салхиар зүйрлэн “Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав” гэж хэлсэн байдаг (Иохан 3:8).

Салхийг харж чадахгүй учраас хаанаас ирээд хаашаа явж байгааг бид мэддэггүй ч салхинд хөдөлж байгаа навчис гэх мэт байгалийн үзэгдлийг хараад салхи байна гэдгийг мэддэг. Яг үүнтэй адил Ариун Сүнснийг харж, барьж үзэж чадахгүй ч Түүний хийж байгаа хүчирхэг ажлуудыг хараад мөн шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа хүний зүрх сэтгэлийг хараад Түүнийг оршин байгааг мэдэрч болдог.

III. Өвчний уг үндэсийг шатааж, харанхуйн хүч, гэмт мөн чанарыг шатаах гал мэт халуун Ариун Сүнсний ажил

“Тэгтэл гал хаялах мэт хэлүүд бий болон хүн нэг бүрийн дээр тогтохыг тэд харлаа” (Үйлс 2:3).

Библид ихэвчлэн Ариун Сүнсний ажлыг ‘гал’-тай зүйрлэн харуулсан байдаг. Иохан Баптист Есүсийн тухай “Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ” гэж хэлсэн (Лук 3:16). Мөн Еврей 12:29т “бидний Бурхан шатаах гал мөн” гэсэн байдаг. Бид гал хүлээн авах үедээ Ариун Сүнсний галаар баптисм хүртдэг.

Хэрэв бид Ариун Сүнсний галын баптисмыг хүлээн авбал бие халуун оргих мэдрэмж төрж, өвчний үндэс шатаж, харанхуйн хүч суларч биднээс холдон зайлах

болно. Бидний гэмт чанарыг мөн дэлхийн бузар зүйлийг шатааж, Бурханы хайрыг чин сэтгэлээсээ мэдрэх хүчийг өгч, бид өөрсдийн хүчээр хэзээ ч хийж чадахгүй зүйлсийг хийх боломжтой болгож өгдөг.

Ариун Сүнсний хүч бүх төрлийн хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэж, бүх зүйлийг боломжтой болгож, ямар ч өвчнийг эдгээдэг. Бүх төрлийн өвчин бүгд гэм нүглээс болж ирдэг учраас эдгэрлийг хүлээн авахын тулд бид эхлээд гэмийн хана хэрмээ нураах ёстой (Египетээс гарсан нь 15:26).

IV. Ариун Сүнсний хүч ер бусын гайхамшиг: Муан амтат ус, эрх мэдэлт хүчтэй гар алчуур, дахин бүтээх хүч, урура гэрэл, соно

“Бурхан Паулын гараар дамжуулан ер бусын гайхамшигуудыг бүтээж байлаа. Алчуур, бүсийг нь түүнээс авч өвчтэй хүмүүст хүргэхэд өвчин нь эдгэж, муу сүнснүүд зайлж байв” (Үйлс 19:11-12).

Библи гайхамшигтай хийгээд гайхалтай зүйлсээр дүүрэн байдаг. Есүс усны мандал дээгүүр явж, салхи, тэнгисийн давалгааг номхтгож, таван талх, хоёр загасаар олон мянган хүнийг хооллож, үхээд дөрөв хоносон Лазарыг дахин амилуулдаг.

Элч Паул Петр нар Ариун Сүнсний хүчийг авч үхсэн хүнийг амилуулж, төрөлхийн доголлон хүнийг явж, үсэрч чаддаг болгосон (Үйлс 3:1-10, 14:8-10). Элч Паулын алчуур, бүсэнд нь хүрсэн хүмүүс эдгэж, муу ёрын бузар сүнснүүд холдон зайлж байсан гэх мэт гайхамшигуудыг үзүүлж байсан (Үйлс 19:11-12).

Бурхан өчигдөр ч өнөөдөр ч яг адилхан оршин байгаа. Хэрэв бид итгэвэл бүхнийг чадагч Бурхан өнөөдөр ч хүний төсөөлөлөөс даван гарсан агуу гайхамшигуудыг Ариун Сүнсний хүчээр хийхийг бидэн зөвшөөрсөөр байгаа билээ. Есүс Иохан 14:12т “Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Надад итгэдэг хүн Миний хийдэг ажлуудыг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно. Яагаад гэвэл Би Эцэгтээ очно” гэсэн байдаг. Бүх алдар, магтаал, талархалыг Ариун Сүнсний гайхамшигтай хүчээр Үгийг батлан харуулж, үзүүлсээр байгаа Бурхандаа өргөцгөөе!

Би Хиндү гэр бүлд төрж өссөн, Христэд итгэнэ гэж хэзээ бодож байгаагүй. Гэтэл 20 настай байхдаа коллежийнхна нэгэн профессороос Христийн тухай сонсоод Эзэнийг хүлээн авсан.

Тэгээд онош нь тодорхойгүй өвчнөөр өвчилж бараг үхэж байсан ээж маань цоо эрүүл болж эдгэрсэн билээ. Үүнийг харсан гэр бүлийнхэн маань бүгд Итгэгч болж, итгэлийн амьдралаар чин сэтгэлээсээ хичээн зүтгэж амьдарч байхдаа нэгэн пасторын охин Присила Наварожи Оуэнтэй гэрлэсэн.

Миний хадам аав пастор Оуэн Робертс Сайн Самари Хүн холбооны ерөнхийлөгч, Энэтхэгт маш олон итгэгчдийн хайрыг хүлээсэн нэр хүндтэй хүн байсан. Тэр И Жейруг Тэргүүн Пасторын 2002 онд Энэтхэгт хийсэн нэгдсэн их цуглааныг зохион байгуулах хорооны ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Тэр үед би Карунья Их Сургуульд химийн профессор байсан юм. Би түүнд залбирлаар туслаж, Энэтхэгийн Христийн түүхэнд гурван сая гаруй хүний анхаарлыг татаж чадсан амжилттай зохион байгуулагдсан хамгийн сайн цуглаан болсон.

И Жейруг Тэргүүн Пасторын сургаал нь маш ойлгомжтой, тодорхой байсан бөгөөд түүний залбирлаар тоологдошгүй олон хүмүүс төрөл бүрийн өвчнөөсөө ангижран эрүүл саруул болж байлаа. Энэ цуглаан нь Энэтхэгийн Христийн сүмүүдийн сэргэлтэнд маш их нөлөөлсөн.

Дараа нь Пастор Оуэн Робертс Энэтхэгийн Христийн сүмүүдийг нэгтгэн, сэргээхээр Тамил Наду-д Пентикост сүмүүдийн ерөнхийлөгч, үүсгэн байгуулагчаар ажиллаж

“Бурханы хайр болон Түүний хүч чадлыг биеэрээ амсаж мэдэрлээ”

Жорж Роберт пастор

52 настай, Магтаалын Цамхаг сүмийн Тэргүүн пастор, Энэтхэг



Доктор Жорж Роберт эхнэр хатагтай Присила Наварожи Оуэны хамт Муан Амтат усны аквариумын өмнө

өөрийгөө бүрэн зориулсан билээ.

2003 онд би И Жейруг Тэргүүн Пасторын “Загалмайн утга учир” сургаалын хөтөлбөрийг Тамил хэлээр хөрвүүлэх ажилд нэгдэн оролцсон. Мөн түүний гэрчлэл *Үхлийн өмнөх мөнх амийг амссан нь* гэсэн номыг Тамил хэлээр засварлаж Бурханы гайхамштай хүслийг ойлгож, маш их мэдэрсэн. Дараа нь Магтаалын Цамхаг сүмд явж сайн дураараа хэд

хэдэн ажил хийсэн. Пастор Оуэн Робертс намайг пастор болж өөрт туслахыг хүссэн.

2010 онд тэр нас барж, Бурхан намайг дуудаж байгааг мэдрээд пастор болсон.

Гэсэн ч би И Жейруг Тэргүүн Пасторын сургаалын хөтөлбөрийг болоод өөр олон хөтөлбөрүүдийг GCN (www.gcnetv.org)-ээр үзсээр байсан бөгөөд Манмин Төв Сүмд

очиж И Жейруг Тэргүүн Пастортай биечлэн уулзахыг хүсэж байв.

2014 оны 10 сард би Сүүлд ирж Манмины 32 жилийн ойн баярт оролцлоо. Тэргүүн Пастор маш даруухан хүн байсан бөгөөд тэрээр Библид бичигдсэн эрх мэдэлт хүчийг, тэмдэгт гайхамшигуудыг үзүүлдэг жинхэнэ Бурханы хүн байсан. Хүмүүсийн төлөө гэсэн хайраар дүүрэн сэтгэлийг би түүнээс олж харсан. Миний мөрний өвчин ч эдгэрч би ч бас тэр эдгэрлийн гайхамшгийг амссан.

Би зүүн гараа өргөж чаддаггүй байсан бөгөөд сүүлдээ эргүүлж чадахгүй болоод нэг жил орчим болж байлаа. Маш их өвддөг байсан тул зүүн гаргүй байвал надад илүү сайн байх байсан гэж боддог байв. Сайн мэс заслын эмчид үзүүлж, зүү тавиулж, олон төрлийн эм уугаад ч нэмэр болоогүй юм.

Гэтэл гайхамшиг Манмин Сүмийн 32 жилийн ойн баярын хоёр дахь өдөр болж гадаадын олон зочдын хамт И Жей руг пасторын залбирлаар далайн шорвог ус ууж болохоор амтат ус болон хувирсан Муан амтат усны газар очлоо. Тэнд би долоон удаа шумбасаны дараа гараа чөлөөтэй хөдөлгөж чаддаг болсон. Халлелуяа!

Энэтхэгт буцаж ирээд И Жей руг пасторын хайрыг, түүний үйлчлэлийг санаж сүмийнхээ итгэгчиддээ хайраар үйлчлэхийг хичээж байлаа. Мөн интернетээр түүний сургаалуудыг үргэлжлүүлэн сонсож, Энэтхэг дэх Ченнай Манмин Сүмийн пастор Жосеф Ханаас сургаалууд авдаг байлаа.

Бүх алдар, магтаалыг ийм үнэтэй ариун нандин сургаалыг надад мэдүүлж, замчилж өгсөн Бурхандаа өргөж байна!

“Аавыг минь аварч, намайг хүүхэд болох ерөөлийг өгсөн Эзэндээ баярлалаа!”

Чиллина эгч дүүс, 29 настай, Хятад

Би Хятад улсын Гилин хотод төрж, ээжийгээ дагаж сүмд явдаг байсан ч итгэлийн амьдралаар сайн амьдардаггүй байлаа.

Аав маань маш огцом ууртай, хатуу ширүүн, хүн байсан. Ээжийгээ зодуулахыг тэвчиж чаддаггүй байсан тул гэрээсээ явахыг хүсдэг боллоо.

2007 оны 1сард Өмнөд Солонгост ирээд ээжийнхээ хэлсний дагуу Манмин Төв сүмд итгэлийн амьдралаар амьдарч эхэлсэн боловч олон зүйлээс болоод маш их сэтгэлийн дарамтанд орж, богино хугацаанд хурдхан мөнгөтэй болох шаардлагатай байсан учраас сүмд их цөөхөн очдог байв.

Тун ч удалгүй аав ээж хоёр маань солонгост ирсэн. Ээж минь миний төлөө залбирч, аав чихрийн шижин өвчтэй болоод түүндээ маш их өвдөж шаналж байв. Тэднийгээ хараад би маш их гэмшиж, жинхэнэ хайрын Бурхантай уулзсан юм даа.

2002 онд ээж минь аавыг өнгөрсөн амьдралдаа хийсэн гэм нүгэл, буруу зүйлдээ гэмшиж, Тэнгэрийн Оронд оруулж өгөхийн хүсч, түүний өмнөөс нулимстайгаар зуучлан залбирч, гэмшиж, бас түүнд үйлчилж байлаа. Би ч бас аавыгаа уучлахын төлөө залбирахад хариуд түүнийг ойлгож эхэлсэн.

Тэгээд чихрийн шижин өвчнөөсөө болоод аав маань юм харж чадахгүй болж, И Жей руг пасторын залбирлаар дахин харж эхэлсэн. Аав маань мөргөлд оролцож, итгэлтэй болж, бас гэмшсэн.

2013 онд аав минь зүүдэндээ маш

том нуга бас цэцгийн мандлыг хараад илүү их зүйлийг ойлгож, мэдэрсэн. Нэг сүйх тэргэнд суугаад хаашаа ч юм явж, хоёр түлхүүр гардан авч байна гэж зүүдэлсэн гээд маш их баяртайгаар “ямар гоё юм бэ? Ёстой гайхалтай би одоо Тэнгэрийн оронд очно!” гэж яг л жаахан хүүхэд шиг баярлаж байгаад нас барсан.

Энэ онцгой үйл явдлаар дамжуулан Тэнгэрийн Орны итгэл найдвар надад баттай ирж, гайхалтай ивээл, ерөөл миний дээрээс цутгаж билээ.

Сүүлийн хоёр жилийн турш хүүхэдтэй болох гэж их хичээсэн боловч болж чадаагүй. Харин цагаан сарын үеэр И Жей руг пасторын залбирал авсны дараахан жирэмсэлж, 2014 оны 10 сарын 13 нд эрүүл саруул сайхан хүүтэй болсон. Би бүх алдар, магтаалыг Бурхандаа, Эзэндээ өргөж байна!



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин